



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/33

Хажуу шинэ ус

Электрон тамхи худалдан
борлуулахыг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.22, 60 дугаар зүйлийн 60.1.1, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл, 18 дугаар зүйлийн 18.1.1, Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 1/3243 дугаартай тушаал, Аймгийн Засаг даргын А/98 захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Харьяалах нутаг дэвсгэрийн хүрээнд 21 нас хүрээгүй хүнд сордог электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдаа үйлчилгээний газруудад худалдахыг хориглосугай.
2. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Э.Ванчиндорж), Байгаль орчны байцаагч (Д.Мандахцацрал) нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН